



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН
2018 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН**

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хамт олон 2018 оны 3 дугаар улиралд үйл ажиллагаагаа сайжруулан төгөлдөржүүлж, зах зээлд удахгүй танилцуулах шинэ бүтээгдэхүүнийхээ бэлтгэл ажлыг хангасан завгүй улирал болж өнгөрлөө. Хувьцаа эзэмшигч, харилцагч та бүхэнд компанийн 3 дугаар улирлын санхүү, үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг танилцуулж байна.


ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:




“ЛэндМН ББСБ” ХК-ийн нийт харилцагчдын тоо өмнөх улирлаас **30 хувиар өсч 71,183** харилцагчтай боллоо. Компани 3 дугаар улиралд нийт **39.4 тэрбум** төгрөгийн **202,102 удаагийн зээл олгосон** нь өмнөх улирлаас зээлийн дүнгээр **21 хувиар**, олгосон зээлийн тоогоор **26 хувиар** өссөн үзүүлэлттэй байна.

Иргэдэд олгосон нийт зээлийн багцын үлдэгдэл 2018 оны 9 сарын 30-ны байдлаар өмнөх улирлаас **4.2 тэрбум төгрөгөөр өсч 14.5 тэрбум** төгрөгт хүрлээ. Тайлант улиралд 30-аас дээш хоног хугацаа хэтэрсэн **зээлийн багц 3.5 хувь** байгаа бол чанаргүй зээлийн багц **1.8 хувь** байна.


Гэрээт харилцагчийн тоо (өссөн дүнгээр)




Олгосон зээлийн тоо



Олгосон зээлийн дүн (MNT'000)



Зээлийн багц (MNT'000)



САНХҮҮГИЙН ҮР ДҮН

Нийт активын хэмжээ өмнө улирлаас **2.9 тэрбум** төгрөгөөр өсч, **16.9 тэрбум** төгрөгт хүрсэн ба 2018 оны 7, 8 саруудад нийт **2.0 тэрбум** төгрөгийн хаалттай бондыг гаргаснаар нийт гаргасан бондын хэмжээ **4.0 тэрбум** төгрөгт хүрэв.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн 3 дугаар улирлын нийт зээлийн орлогын хэмжээ өмнөх улирлаас **19.4 хувиар** буюу **308.0 сая төгрөгөөр өсч**, нийт **1 тэрбум 895.9 сая** төгрөгийн орлоготой ажилласан ба эхний 9 сарын байдлаар нийт орлогын хэмжээ **4 тэрбум 619.2 сая төгрөгт** хүрэв. Харилцагчийн төлөх шимтгэлийн хэмжээг бууруулснаар зээлийн багцын өгөөж өмнөх улирлаас **12 хувиар** буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд компани **157,977,647** төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулснаар ирээдүйд учирч болзошгүй зээлийн эрсдэлээс хамгаалах сангийн хэмжээ **273,460,600** төгрөгт хүрэв. Компанийн үйл ажиллагаа өсөн, цар хүрээ өргөжиж байгаатай уялдан зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор шинээр бонд нэмж гаргаснаар хүүгийн зардал өмнөх улирлаас **98.5 сая** төгрөгөөр, гүйлгээний шимтгэл болон үйл ажиллагааны зардал өмнөх улирлаас **21.4 хувиар** тус тус өслөө.

“ЛэндМН ББСБ” ХК өнгөрсөн улиралд **763.2 сая** төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 2018 оны эхний 9 сарын цэвэр ашгийн хэмжээ **2.0 тэрбум** төгрөгт хүрлээ. Эхний 9 сарын байдлаар компанийн өөрийн хөрөнгийн өгөөж **19.5%-д**, нийт активын өгөөж **16.3%-д**, нэгж хувьцаанд ногдох цэвэр ашгийн хэмжээ **2.50 төгрөгт** тус тус хүрэв.


Нийт актив, пассив



Орлого болон цэвэр ашиг



Нийт болон өөрийн хөрөнгийн өгөөж



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН



MNT'000	1-р улирал	2-р улирал	3-р улирал
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,421,027	3,109,672	1,723,169
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	7,638,760	10,491,483	14,650,429
Бусад хөрөнгө	8,733	22,851	105,837
Үндсэн хөрөнгө	167,558	252,943	259,609
Биет бус хөрөнгө	263,503	256,345	248,461
Нийт хөрөнгө	12,499,582	14,133,293	16,987,505
Богино хугацаат хаалттай бондын өглөг	1,000,000	2,000,000	4,000,000
Богино хугацаат бусад өглөг	249,585	116,632	207,642
Нийт өр төлбөр	1,249,585	2,116,632	4,207,642
Хувьцаат капитал	11,000,000	11,000,000	11,000,000
Хувьцаа нэмж гаргахтай холбоотой шууд зардал	(243,141)	(243,141)	(243,141)
Хуримтлагдсан ашиг	493,138	1,259,803	2,023,004
Нийт эздийн өмч	11,249,997	12,016,662	12,779,863
Нийт өр төлбөр болон эздийн өмч	12,499,582	14,133,294	16,987,505

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН




MNT'000	1-р улирал	2-р улирал	3-р улирал	2018 оны эхний 9 сар
Шимтгэл болон түүнтэй адилтгах орлого	1,135,435	1,587,871	1,895,889	4,619,195
Хүүгийн зардал	(44,055)	(46,137)	(144,638)	(234,830)
Цэвэр орлого	1,091,380	1,541,734	1,751,251	4,384,365
Зээлийн болзошгүй эрсдлийн нөөцийн зардал	(46,890)	(53,243)	(157,977)	(258,110)
Үйл ажиллагааны цэвэр орлого	1,044,490	1,488,491	1,593,274	4,126,255
Удирдлагын болон ҮА-ны зардал	(433,267)	(637,278)	(740,290)	(1,810,835)
IPO-той холбоотой нэг удаагийн зардал	(79,610)	-	-	(79,610)
Нийт зардал	(512,876)	(637,278)	(740,290)	(1,890,444)
Татварын өмнөх ашиг	531,613	851,213	852,985	2,235,811
Татварын зардал	(57,014)	(84,549)	(89,783)	(231,346)
Цэвэр ашиг	474,599	766,664	763,202	2,004,465

ЛЭНДМН ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцааны арилжаа МХБ-ийн арилжаанд тэргүүлээ хадгалж, 2018 оны 3 дугаар улиралд нэг өдрийн арилжааны дундаж дүн болон тоо ширхэгийн үзүүлэлтээр биржийн үзүүлэлтүүдийг тэргүүлсэн хэвээр байна. “ЛэндМН” хувьцааны ханш өнгөрсөн 3 дугаар улиралд өмнөх улиралтай харьцуулахад **16%-аар** өсч 2018 оны 9 сарын 28-ны өдрийн хаалтын ханшаар **66.05** төгрөгт хүрч хаагдлаа.


ЛэндМН хувьцаа нь анх 2018 оны 3 дугаар сарын 14-нд МХБ-ийн **III самбар** дээр хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалагдсанаас хойш арилжааны ерөнхий үзүүлэлтүүдээрээ тэргүүлж Монголын Хөрөнгийн Биржийн **II самбарт шилжин**, ангилал ахилаа.

НЭГ ӨДРИЙН АРИЛЖААНЫ ДУНДАЖ ДҮН (3 УЛИРАЛ, 2018)




Эх сурвалж: МХБ

БИРЖИЙН ӨДРИЙН НИЙТ АРИЛЖСАН ХУВЬЦААНД ЭЗЛЭХ ХУВЬ (3 УЛИРАЛ, 2018)




БИРЖИЙН ӨДРИЙН НИЙТ АРИЛЖААНЫ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ (3 УЛИРАЛ, 2018)



● ЛЭНДМН
 ● СҮҮ
 ● АПУ
 ● ГОВЬ
 ● ТАВАН ТОЛГОЙ
 ● МОНГОЛ ШУУДАН
 ● БУСАД

Эх сурвалж: МХБ

ХААЛТЫН ХАНШ 



ХАНШИЙН
ӨСӨЛТ

16%

НИЙТ АРИЛЖААЛАГДСАН
ШИРХЭГ

21'100'976


НИЙТ АРИЛЖААЛАГДСАН
ҮНИЙН ДҮН

1'386'831'524₮

Эх сурвалж: МХБ

ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ: 

“ЛэндМН ББСБ” ХК 2018 оны 5 дугаар сард цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрлөө авсан билээ. Анд Системс Тех ХХК-ийн технологийн баг, ЛэндМН-ийн баг хамтран цахим төлбөр тооцооны шинэ бүтээгдэхүүн болох “Лэнд Хэтэвч” шинэ шийдлээ хөгжүүлж, туршилт болон нэвтрүүлэлтийн бэлтгэл ажлаа ханган, 2018 оны 10 сард багтаан танилцуулахад бэлэн болоод байна. Шинэ бүтээгдэхүүн зах зээлд нэвтэрснээр ЛэндМН аппликейшнаар дамжуулан гар утсаараа төлбөр тооцоо хийх, мөнгө шилжүүлэх зэрэг цахим төлбөр тооцооны нэмэлт олон төрлийн үйлчилгээг Илүү хялбараар Хэзээ ч, Хаанаас ч авах боломжийг “Лэнд Хэтэвч” үйлчилгээ хүнд бүрт олгох юм.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2018 оны 3 дугаар улиралд ээлжит болон ээлжит бус хоёр удаа хуралдаж, Компанийн 2018 оны 2 дугаар улирлын тайлан, санхүүгийн гүйцэтгэл, төсвийн асуудлыг хэлэлцэж, компанийн шинэ бүтэц, орон тоог батлах, компанийн дотоод аудиторыг томилох шийдвэр гаргасан.

Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс Аудитын хорооны саналыг үндэслэн Батнямын Тэмүгэг “ЛэндМН ББСБ” ХК-ийн Дотоод аудитороор томилсон бөгөөд Б.Тэмүгэ нь Дотоод аудитын чиглэлээр сүүлийн 3 жил ажилласан туршлагатай, эрч хүчтэй, залуу мэргэжилтэн юм.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн тухай

Монгол улсын санхүүгийн зах зээлд анх удаа технологийн дэвшлийг санхүүгийн үйлчилгээтэй хамтатгасан Финтек бизнес моделийг LendMN аппликейшнээр дамжуулан амжилттай нэвтрүүлж буй барьцаагүй, хэрэглээний бичил цахим зээлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага юм.

Холбоо барих:

ЛэндМН ББСБ ХК-ийн ТУЗ-ийн
нарийн бичгийн дарга: Ч. Намираа
Утас: 7722-2949

Имэйл: contact@lend.mn
board@lend.mn